



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТ ТАЙЛАН

Аудитын код: **ҮАГ-НАГ/2015/04-НА**

Аудитын нэр: **Монгол Улсын Засгийн газрын
тусгай сангийн 2014 оны үйл ажиллагааны
үр дүн**

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ХӨРӨНГИЙГ
ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ УЯЛДУУЛАН БҮРДҮҮЛЖ,
ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТААР НЬ ЗАРЦУУЛЖЭЭ**

Зохион байгуулалтын нэгж: **НИЙЦЛИЙН АУДИТЫН БАГ**



2015 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Үндэсний Аудитын газрын харъяа Баян-Өлгий аймгийн аудитын газар Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Бекен Аудитын менежер Х.Женисбек Аудитын баг: Ахлах шинжээч С.Салтанат Шинжээч Х.Еркебулан 2015 оны 09 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70423073 дугаарын утас, 70422954 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар 102, 104, 217 тоот өрөө	Товчилсон үгийн тайлбар3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4 Бүлэг 1. Дархлаажуулалтын сангийн хөрөнгөөр 2014 онд тус аймгийн 40718 хүнд урьдчилан сэргийлэх тарилга хийгджээ. - Дархлаажуулалтын сангийн тухай хууль, эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.....6 2014 оны вакцинжуулалтанд шаардагдах вакциныг хуульд заасны дагуу зөв төлөвлөж, вакциныг татан авч, сангийн хөрөнгийг бүрдүүлжээ.....6 2014 онд хүлээн авсан дархлаажуулалтын сангийн хөрөнгийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу зарцуулж, зохих үр дүнд хүрсэн байна.....9 - Сангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулж, хэрэгжүүлж ирсэн байна.....13 Бүлэг 2. Аймгийн Авто замын санд 2014 онд 256.6 сая төгрөгийн хөрөнгийг төвлөрүүлж, зориулалтаар нь зарцуулжээ. - Авто замын сангийн тухай хууль, эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.....18 - Авто замын санд 2014 онд хуульд заасны дагуу 256.6 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлж, оны эцэст 35.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.....19 - Авто замын сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулжээ.....20 - Авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулж ажиллаж ирсэн байна.....22 Бүлэг 3. Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгөөр 2014 онд тус аймаг хоёр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлжээ. - Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.....26 - Шинжлэх ухаан технологийн санд 2014 онд 139.0 сая төгрөгийн батлагдсан төсвийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулжээ.....27 - Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, судалгааын ажлыг журмын дагуу зохион байгуулжээ.....27 - Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулж ажиллаж ирсэн байна.....29 Дүгнэлт.....14,25,30 Зөвлөмж:15 Холбогдох байгууллагын санал:16,17,26,31 Саналд өгсөн тайлбар
---	--

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал	
ШУА	Шинжлэх ухааны академи	
ССАЖС	Соёл, спорт аялал жуулчлалын сайд	
ЭМЯ	Эрүүл мэндийн Яам	
ЭМГ	Эрүүл мэндийн газар	
ЭМТ	Эрүүл мэндийн төв	
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв	
ЗӨСҮТ	Зооноз өвчин судлалын үндэсний төв	
ЗӨСТ	Зооноз өвчин судлалын төв	
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	
ЗДТГ	Засаг даргын тамгын газар	
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс	
МХЕГ	Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар	
НЭЗСТ	Нийгэм эдийн засгийн судалгааны төв	
НД	Нийгмийн даатгал	
АТБӨЯХАТ	Автотээвэр болон өөрөө явах хэрэгсэлийн албан татвар	
ШУТС	Шинжлэх ухааны технологийн сан	

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Аудитыг Монгол УИХурлын Төсвийн Байнгын хорооны 2014 оны “Аудитын сэдэв батлах тухай” 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторос баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Засгийн газрын тусгай сангийн хуулиар тодорхойлсон “Дархлаажуулалтын сан”, “Соёл урлаг хөгжүүлэх сан”, “Автозамын сан”, “Шинжлэх ухаан технологийн сан”-гуудын 2014 оны үйл ажиллагаа, эдгээр сангаар хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган, аудитын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, санал зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Энэхүү аудитад “Дархлаажуулалтын сан”, “Автозамын сан”, “Шинжлэх ухаан технологийн сан”-гуудын 2014 оны үйл ажиллагаа хамрагдаж Монгол УИХурал, Засгийн газар, холбогдох яам, аймгийн ИТХурал, Засаг дарга, бусад байгууллагуудаас гаргасан холбогдох шийдвэрүүд, зохион байгуулсан ажлын үр дүн, “Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө”-гийн хөтөлбөр, төсөл арга хэмжээнүүдтэй холбоотой иргэдээс гаргасан санал, ажлын явцын болон холбогдох санхүүгийн ажлын тайлан, бусад тооцоо судалгаанд үндэслэн аудитыг хэрэгжүүлэв.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын арга зүйг ашиглан, аймгийн Эрүүл мэндийн газар, Орон нутгийн музей, Нийгмийн Шинжлэх ухааны төв, Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс бусад хэлтсүүдийн удирдах холбогдох албан тушаалтнуудтай ярилцах, санал, асуулга, лавлагаа авах, судалгаа авч дүн, шинжилгээ хийх, зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг ахлах шинжээч С.Салтанат ахалж, шинжээч Х.Еркебулан нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг гүйцэтгэж Дархлаажуулалтын сан, Автозамын сангийн үйл ажиллагаанд ахлах шинжээч С.Салтанат, Шинжлэх ухаан технологийн сангийн үйл ажиллагаанд шинжээч Х.Еркебулан аудит хийж, тайланг бэлтгэсэн болно.

Хүндрэл бэрхшээл:

Дархлаажуулалтын сангийн үйл ажиллагаанд нийцлийн аудит хийх явцад ЭМГазрын дархлаажуулалтын үйл ажиллагаа хариуцсан их эмч нь жирэмсэний чөлөө авсан, Зооноозын өвчин судлалын төвийн дарга нь 2014 оны 5-р сард, халдвар судлаач их эмч нь 2015 оны мөн 5-р сард ажилд шинээр орсон гэх мэт шалтгаанаар зарим баримт, материал бүрэн бус байгаагаас аудит хийхэд бэрхшээл учирч байсан.

Бүлэг 1

Дархлаажуулалтын сангийн хөрөнгөөр 2014 онд тус аймгийн 40718 хүнд урьдчилан сэргийлэх тарилга хийгджээ.

Оршил

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Засгийн газрын тусгай сангийн хуулиар тодорхойлсон “Дархлаажуулалтын сан”, “Соёл урлаг хөгжүүлэх сан”, “Автозамын сан”, “Шинжлэх ухаан технологийн сан”-гуудын 2014 оны үйл ажиллагааны үр дүнд 2015 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 09 дүгээр сарын 22-ныг хүртэл хугацаанд нийцлийн аудит хийлээ.

“Соёл урлаг хөгжүүлэх сан”-гийн хөрөнгөөр ССАЖСайдын 2014 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн А/114 тоот тушаалаар тус аймгийн Орон нутгийн судлах музейд 8 төрлийн нийтдээ 1560.0 мянган төгрөгийн үзмэр худалдан авахаар шийдвэр гарсан боловч тухайн үед яамны мэргэжлийн зөвлөлийн материалыг соёл, урлаг хөгжүүлэх санд өгөхдөө худалдан авах үзмэрийн тоо, ширхэгийг 8 ш гэж бичих ёстойг 1 ш гэж алдаатай бичиж өгсөнөөс болж тоо, ширхэгийн зөрүү гарч улмаар батлагдсан санхүүжилтийг авч чадаагүйгээс тухайн үзмэрүүдийг сан хөмрөгт худалдан аваагүй байна.

Мөн ССАЖСайдын 2014 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/38, 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/ 111 тоот тушаалаар 2014 оны 3 дугаар сард “Кара жорга-урлагийн баяр” өдөрлөгийг тус аймгийн нутгийн зөвлөл Улаанбаатар хотод Чингисийн талбайд зохион байгуулахаар төлөвлөж, 4,0 сая төгрөгийн хөрөнгө батлагдаж, эрх нээгдсэн боловч тэнд зохион байгуулагдсан тул хөрөнгийн зарцуулалтанд энд аудит хийх боломжгүй байна.

Харин 2007 онд УИХ-аар батлагдсан “Сэргээгдэх эрчим хүчний тухай” хуулиар Сэргээгдэх эрчим хүчний сан байгуулахаар заасан боловч байгуулагдсан цагаас нь эхлэн улсын төсвөөс хөрөнгө төвлөрүүлж, зарцуулаагүй байна.

“Орон сууцны сан”-г 2012 онд татан буулгаж, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр оруулсан өөрчлөлтөөр хүчингүй болсон байна. Иймд дээрхи гурван сангийн хөрөнгөөр тус аймагт ямар нэгэн үйл ажиллагаа явагдаагүй байна.

1. Дархлаажуулалтын сангийн үйл ажиллагааны талаар.

1. Дархлаажуулалтын сангийн хууль, эрх зүйн зохицуулалт оновчтой эсэх.

Дархлаажуулалтын сангийн тухай хууль, эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.

Монгол Улсын хүн амыг халдварт өвчнөөс сэргийлэх, дархлаажуулалттай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Дархлаажуулалтын тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаар 2000 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр баталж, мөрдөж эхэлсэн байна.

Энэхүү хуулийг баталснаар дархлаажуулалтын талаархи төрийн бодлого, дархлаажуулалтын талаархи иргэний эдлэх эрх, хүлээх үүрэг, үйл ажиллагааны зохион байгуулалтын үндэс, дархлаажуулалтын үйл ажиллагааны санхүүжилт, тарилгын дараах хүндрэл зэрэг бусад үйл ажиллагааг Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Ариун цэврийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хүрээнд нягт уялдуулан зохицуулсан байна.

Энэхүү хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3.2-т заасны дагуу дархлаажуулалтын талаархи төрийн бодлогыг төв, орон нутгийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллага хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийнхээ хүн амыг дархлаажуулах тусгай хөтөлбөр баталж мөрдөж ажиллах ёстой.

Дээрхи хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Дархлаажуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” дархлаажуулалтын сангийн ажиллах журам, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайдын 1997 оны А/219 тушаалаар батлагдсан “Вакцинжуулалтын явцад баримтлах хүйтэн хэлхээний журам”, “Вакцины хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн байнгын үйлчилгээ хяналтын журам”, “Вакциныг төлөвлөх, нөөцлөх, бүртгэх журам”, Эрүүл мэндийн сайдын 2011 оны “Вакцин, биобэлдмэлийн хаягдлыг устгах журам”-уудыг мөрдөж ажиллаж ирсэн байна.

2. Дархлаажуулалтын сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж, бүрэн бүрдүүлсэн эсэх.

2014 оны вакцинжуулалтанд шаардагдах вакциныг хуульд заасны дагуу зөв төлөвлөж, вакциныг татан авч, сангийн хөрөнгийг бүрдүүлжээ.

2.1 Дархлаажуулалтын сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу үндэслэлтэй төлөвлөсөн эсэх.

2.1.1 Дархлаажуулалтын тухай хуулийн 5.2-т “Дархлаажуулалтын талаархи төрийн бодлогыг төв, орон нутгийн төрийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллага хэрэгжүүлнэ”, 5.3.2-т “нутаг дэвсгэрийнхээ хүн амыг дархлаажуулах тусгай хөтөлбөр батлах” гэж заасан байна. Үүний дагуу шалгаж үзэхэд Засгийн газрын 2011 оны 108 тоот тогтоолоор батлагдсан “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх талаар аймгийн ЭМГазраас тодорхой ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.

2.2.2 Хуулинд зааснаар үндэсний товллолт буюу заавал хийх дархлаажуулалт, тархвар судлалын заалтаар хийх сэргийлэх тарилга, сайн дурын дархлаажуулалт гэж ангилан дархлаажуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн байна.

Үндэсний товллолт вакцин буюу заавал хийгдэх дархлаажуулалтын вакцинд сүрьеэ, халдварт саа, В вируст гепатит, сахуу, хөхүүл ханиад, татран, улаанбурхан, В хэв шинжийн хемофлюс инфлюэнза нянгийн халдвар, гахай хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилга, Тархвар судлалын заалтаар хийгдэх вакцинд халдварт өвчин гарч болзошгүй нөхцөлд хийх тарваган тахал, боомын вакцинууд, сайн дурын дархлаажуулалтаар хийгдэх вакцинд балнад, томуу, А гепатитын вакцинууд тус тус хамрагддаг байна.

2.2.3 Дархлаажуулалтын тухай хуулийн 17.1, Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дархлаажуулалтын сангийн ажиллах журам”-ын 11.в, Эрүүл мэнд нийгмийн хамгаалалын сайдын 1997 оны 219 тоот тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Вакцинийг төлөвлөх, нөөцлөх, бүртгэх журам”-д зааснаар дархлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүх газарт вакцины хэрэгцээг тодорхойлоход эрүүл мэндийн нэгж, сум, аймгийн түвшинд жилд вакцинжуулалтад хамрагдах хүүхдийн тоо, вакцин тус бүрээр хүүхэд бүрт шаардагдах тунгийн тоо, вакцины төрөл тус бүрээр вакцины хорогдлыг тооцсон дундаж тоо, жилд хийх хангалтын тоо, тухайн нутаг дэвсгэрт вакцин хадгалах тоног төхөөрөмжийн хүчин чадал, хөргөгч, хөлдөөгч, хүйтэн сав, вакцины зөөврийн сав, вакциныг тооцсоны үндсэн дээр тухайн жилд шаардлагатай вакцины захиалгыг өгдөг байна.

Вакциныг тооцоолоход эн тэргүүнд тухайн нутаг дэвсгэрт жилд шинээр төрөх хүүхдийн тоог оруулж тооцох юм байна.ЭМГазраас вакцины хангалтыг төлөвлөхдөө журамд заасны дагуу вакцины үлдэх бага нөөцийг тооцож, хэрэгцээт вакцинаа захиалж, вакцинаар тасралтгүй хангаж ирсэн байна.

2.2.4 Зооноз өвчин судлалын төв нь 2014 онд шаардлагатай тархвар судлалын заалтаар хийгдэх тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины хэрэгцээг 2013 оны 1 дүгээр улиралд тооцож, 4520 хүн тунг ЗӨСҮТөвд захиалсан байна.

2.2.5 ЭМГазар нь 2014 онд дархлаажуулалтад шаардлагатай вакцины тоо, төлөвлөгөөг гаргахдаа дээрхи хууль, тогтоомжийн заалтууд болон Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс ирүүлсэн 2013 оны 03 дугаар сарын сарын 22-ны өдрийн 11/198 албан тоотыг үндэслэн 2014 оны төлөвлөгөөг жилийн өмнө боловсруулж, ЭМГазрын 2013 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 226 албан тоотоор ХӨСҮТөвд хүргүүлсэн байна. Энэхүү төлөвлөгөө буюу захиалгад сүрьеэгийн вакциныг 21642, тавтын вакциныг 10502, сахуу татрангийн вакциныг 8400, халдварт саагийн вакциныг 22915, улаанбурхан, гахайн хавдар, улаануудын вакциныг 7640, гепатит В вакциныг 7320, гепатит А вакциныг 6430, тархвар судлалын заалтаар хийгдэх гепатит А вакциныг 5000, менингит вакциныг 500 хүн тунгаар тус тус төлөвлөж, захиалсан байна.

Тус газар нь 2014 онд заавал хийх дархлаажуулалтанд шаардагдах вакцины төлөвлөгөө буюу хүн тунгийн тоог гаргасан байдлыг шалгаж үзэхэд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997 оны 219 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан журамд заасан томъёо, итгэлцүүрийг ашиглаж, вакцин тус бүр дээр тооцож, 2014 онд хэрэгцээт вакцины захиалгыг төлөвлөсөн байна. Тухайлбал:

2014 оны захиалгыг тооцохдоо их нөөц, бага нөөцөө тооцсон байна.

Их нөөц=хамрагдвал зохих хүүхдийн тоо*вакцины тун*хорогдлын индекс/жилд хүлээн авах тоо+бага нөөц

Бага нөөц= хамрагдвал зохих хүүхдийн тоо*вакцины тун*хорогдлын индекс/жилд хүлээн авах тоо*25%/100%

Жишээ нь: Сүрьеэгийн вакцины төлөвлөгөөг тооцохдоо

Хамрагдвал зохих хүүхдийн тоо-2546. Энэ нь 2011, 2012 оны төрсөн хүүхдийн дунджаар авсан тоо.

Вакцины тун- сүрьеэгийн вакциныг 1 тунгаар тарьдаг

Хорогдлын индекс-6.8 Үүнийг 2012 оны 4-р сарын мэдээг үндэслэж тооцсон байна.

Жилд хүлээн авах тоо- 1 жилийн вакцины захиалга учраас 1 удаа гэж авсан байна.

Бага нөөц= $2546 \times 1 \times 6.8 / 1 \times 25 / 100 = 4328.2$


Их нөөц= $2546 \times 1 \times 6.8 / 1 + 4328.2 = 21642$ (2014 онд шаардагдах нийт вакцины хэрэгцээ хүн тунгаар)

Вакцины 1 хүүхдэд таригдах тун

д/д	Вакцины нэр	Таригдах тун
1	Сүрьеэгийн вакцин	1 тун
2	Саагийн вакцин	4 тун
3	В гепатит	1 тун
4	Тавт вакцин	3 тун
5	Улаанбурхан гахайн хавдар улаануудын хавсарсан вакцин /УГУ/	2 тун
6	А гепатит	2 тун
7	Сахуу татран	2 тун

2.2 Дархлаажуулалтын сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төрөл тус бүрээр бүрдүүлсэн эсэх.

2.2.1 Зооноз өвчин судлалын төв нь 2013 оны 1 дүгээр улиралд тархвар судлалын заалтаар хийгдэх тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 4520 хүн тунг ЗӨСҮТөвд захиалсан бөгөөд 2014 онд ЗӨСҮТөвөөс Казахстан Улсад үйлдвэрлэгдсэн 3000 хүн тун буюу нийтдээ 15.1 сая төгрөгийн тарваган тахлын дархлаажуулалтын вакцин, 225.0 мянган төгрөгийн зүү, тариур захиалгын дагуу ирсэн боловч тус төвд хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж байгаагүй тул аймгийн ЭМГазарт хүргэгдэж тэндээ хадгалагдсан байна.



ЭМГ-ын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж

2.2.2 ЭМГазар нь 2013 оны 04 дүгээр сард 2014 оны дархлаажуулалтад шаардагдах вакцины захиалгыг ХӨСҮТөвд хүргүүлж, 2014 онд нийтдээ 12 төрлийн 158.9 сая төгрөгийн 68652 хүн/тун товлотт вакциныг татан авч, ЭМГазрын хүйтэн хэлхээний төхөөрөмжид хадгалсан байна. Мөн нийтдээ 3.0 сая төгрөгийн зүү, тариур татан авч дархлаажуулалтын арга хэмжээнд хэрэглэсэн байна.

3. Дархлаажуулалтын сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх.

2014 онд хүлээн авсан дархлаажуулалтын сангийн хөрөнгийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу зарцуулж, зохих үр дүнд хүрсэн байна.

3.1 Дархлаажуулалтын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байгаа эсэх.

3.1.1 Дархлаажуулалтын тухай хуулийн 17.1, Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дархлаажуулалтын сангийн ажиллах журам”-ын 11.в, Эрүүл мэнд нийгмийн хамгаалалын сайдын 1997 оны 219 тоот тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Вакцинийг төлөвлөх, нөөцлөх, бүртгэх журам”-ын дагуу ЭМГазар болон Зооноз өвчинтэй тэмцэх газар нь 2014 онд хийгдэх дархлаажуулалтын вакцины хэрэгцээг тооцож, төлөвлөж, захиалж, нийтдээ 71652 хүн тун буюу 174.0 сая төгрөгийн вакциныг хүлээн авч, тус аймгийн нийтдээ 40672 хүнд 40718 хүн тун вакцины дархлаажуулалтын арга хэмжээ авсан нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байна.

3.2 Төсөл, хөтөлбөрийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулж, гэрээний шаардлагыг хангасан эсэх.

3.2.1 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалт болон “Дархлаажуулалтын тухай хууль”-ийн 17.1, Засгийн газрын 2001 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар тогтоолоор батлагдсан “Дархлаажуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай журам”-ын 4-т заасны дагуу Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зооноз өвчинтэй тэмцэх үндэсний төвөөс бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг түүгээрээ зохион байгуулж, аймгуудыг захиалгын дагуу 2014 оны дархлаажуулалтад шаардагдах вакцинаар хангасан байна. 2014 онд аймгаас хүргүүлсэн захиалгын шаардлагыг үндсэндээ хангаж ажилласан байна.

3.3 Дархлаажуулалтын хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрсэн эсэх.

3.1 ЭМГазарт дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн 1, бага эмч 1, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийтдээ 18 орон тооны вакцинатор сувилагч, Нэгдсэн эмнэлгийн хүлээн авах тасагт ээлжийн 4 сувилагч, төрөх тасагт 4 нярайн сувилагч аймгийн хэмжээгээр нийтдээ 28 эмнэлгийн мэргэжилтэн дархлаажуулалтын үйл ажиллагааг гүйцэтгэж ирсэн байна. Мөн Зоонозын өвчин судлалын төвд дархлаажуулалтын үйл ажиллагааг 1 мэргэжилтэн, их эмч хариуцан ажиллаж байна.

3.2 2014 онд Засгийн газрын 2011 оны 108 тоот тогтоолоор батлагдсан “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор

ХӨСҮТөвийн 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 11/746 албан тоот, ЭМГазрын даргын 2014 оны 05 дугаар сарын 28-ний өдрийн 56 тоот, 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 683 тоот тушаалын дагуу “Заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон хүүхдийг нөхөн дархлаажуулья” уриан дор 2 удаа дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулсан байна.

Үүнтэй уялдан бүх сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нөхөн дархлаажуулалттай холбоотой гарсан тушаал, нөхөн дархлаажуулалт хийх заавар, мэдээ ирүүлэх маягт, дархлаажуулалтад шаардагдах вакцин, зүү, тариур, аюулгүй хайрцаг зэргийг сум, өрхийн төвүүдэд хүргүүлж, олон нийтийн үйлчилгээний газрууд, хүүхдийн байгууллага, орон нутгийн радиогоор дархлаажуулалтын 10 хоногийн ач холбогдол, үндэсний товллын вакцин, нөхөн дархлаажуулалт хийх заалт, улаанбурхан өвчний талаар цуврал нэвтрүүлэг, ХӨСҮТөвөөс ирүүлсэн ТВ шторк зэргийг орон нутгийн радио, телевизээр сурталчилан нэвтрүүлжээ.

ХӨСҮТөвийн мэргэжилтнүүд 2014 оны 05 дугаар сарын 04-нд орон нутагт ирж “Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, цочмог сул саажилт, халууралт, тууралт, хам шинжийн урвалын тандалтыг эрчимжүүлье” сэдэвт 1 өдрийн сургалтыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын эмч, бага эмч, вакцинолог, ЗӨСҮТөвийн лаборант, эмч зэрэг нийтдээ 50 хүнд сургалт зохион байгуулсан байна.

Аймгийн ЭМГазраас 2014 оны 05 дугаар сарын 10-нд сум, өрхийн ЭМТөвийн эрхлэгч нарт халууралт, тууралт, хам шинжийн урвалын тандалтын явц, эргэн мэдээллийн сургалт зохион байгуулж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, цочмог сул саажилт, халууралт, тууралт хам шинжийн тандалтыг эрчимжүүлэх талаар харъяа байгууллагуудад ажил зохион байгуулах даалгавар хүргүүлсэн байна.

“Мейрим”, “Жансая”, “Рауан” өрхийн ЭМТөв, Баяннуур сумын ЭМТөв, Ногооннуур, Цэнгэл сум дундын эмнэлгүүдийн вакцинологуудыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд вакцинологын мэргэжил олгох 3 сарын сургалтанд хамруулсан байна.

Тайлангийн хугацаанд 8 удаа вакцин, биобэлдмэлийг зохих журмын дагуу хүлээн авч шаардлагын дагуу хадгалж, харъяа нэгж, байгууллагад сарын нөөцөөр захиалгыг үндэслэн нийлүүлж, зохих журмын дагуу анхан шатны маягтуудыг хөтлөж ирсэн байна. Төвөөс ирсэн аливаа вакцины эргэн мэдээллийг ЭМСайдын 122 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу хугацаанд нь гаргаж, 2014 онд 8 удаа цахим хэлбэрээр явуулсан байна.

Сум, өрхийн эмнэлгүүдээс тарилгын мэдээг сар бүрийн 30-наас дараа сарын 03-ны хооронд авч нэгтгэн, дараа сарын 10-ны дотор ХӨСҮТөвд 2014 онд 12 удаа цахим болон хэвлэмэл байдлаар хүргүүлж байжээ. Мөн цочмог саажилтын тандалтын мэдээг бүх сум, өрхийн эмнэлэг, аймгийн Нэгдсэн эмнэлгээс авч долоо хоног бүр төвд утсаар болон цахим хэлбэрээр 2014 онд 52 удаа мэдээлж ирсэн байна.

ХӨСҮТөвөөс 2014 онд 3 хөргөгчийг тог баригчийн хамт авч “Мейрим” өрхийн ЭМТөв, Улаанхус сумын ЭМТөв, ЭМГазарт хуваарилсан байна.

3.3 Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайдын 1997 оны 219 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Вакцины хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн

байнгын үйлчилгээ хяналтын журам"-ын дагуу аймгийн ЭМГазар, нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хүйтэн хэлхээний хөлдөөгч, хөргөгч, зөөврийн цүнхээр бүрэн хангасан байна. Тус аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, 12 сум, 1 тосгон, 4 Өрхийн эмнэлгийн төвд 2014 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 63.8 сая төгрөгийн төхөөрөмжтэй байсан ба үүнээс одоогийн байдлаар 16 ширхэг буюу нийтдээ 15.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, ашиглалтын хугацаа нь дууссан, эвдэрсэн шалтгаанаар ажилгүй байгаа тул цаашид засаж сэлбэх, акталж данс, бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байна.

Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн хангалт, холбогдох журмын заалтын дагуу хэвийн ажиллуулж ашиглаж байгаа эсэхийг ЭМГазар, Нэгдсэн эмнэлэг, аймгийн төвийн Өрхийн 4 эмнэлгээр явж газар дээр нь шалгаж үзэхэд шаардлагатай хүйтэн хэлхээний хөргөгч, хөлдөөгч, зөөврийн цүнх, тохижилт сайтай орон байраар хангагдсан ба вакцин хадгалах хөргөгч, хөлдөөгчийн хэм журамд зааснаар хэвийн байсан бөгөөд өглөө, оройн хэмийг тусгай дэвтэрт байнгын хөтөлж ирсэн байна. Аливаа тог тасарсан үед арга хэмжээ авах зориулалтаар бүх салбар, нэгжийг японы цахилгаан үүсгүүр мотороор бүрэн хангасан ба удаан хугацаагаар тог тасарсаны улмаас вакцины чанарт нөлөөлж, вакцин устгасан тохиолдол 2014 онд гараагүй байна.

3.4 Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн сайн дурын дархлаажуулалтанд хамрагдсан тухай судалгааг салбарын хэмжээгээр гаргаж, шаардлагатай арга хэмжээг авах, биобэлдмэлээр хангаж өгөх талаар ХӨСҮТөвд мэдээлсэн зэрэг зохион байгуулалтын арга хэмжээнүүдийн авч ажилласан байна.

3.5 Үндэсний товлолоор хийгдэх дархлаажуулалтаас хоцорсон хүүхдийн судалгааг гаргаж, 127 хүүхдийг дархлаажуулалтад нөхөн хамруулж, тархвар судлалын заалтаар 750 эмч, эмнэлгийн ажилчдыг улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулжээ.

Мөн сайн дурын дархлаажуулалт болон урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдах Засгийн 2001 оны 67 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад дурьдагдсан байгууллага хүмүүсийг хамруулах талаар аймгийн ЭМГазраас зохион байгуулж, 2013 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн 200 их эмч, бага эмч, сувилагч ажилчдыг В гепатит вакцинд, 21 их эмч, бага эмч, сувилагч ажилчдыг тарваган тахлын вакцинд, 2014 онд 17 их эмч, бага эмч, сувилагч, ажилчдыг тарваган тахлын сайн дурын вакцинд хамруулсан байна. Харин 2013 оноос хойш ажилд шинээр орсон зарим ажилтан, ажилчид, бусад байгууллагын ажилчдыг сайн дурын вакцинд хамруулах арга хэмжээ авагдаагүй байна.

3.6 Дархлаажуулалтын явцад дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн тандалт судалгааг байнга хийж ирсэн ба дархлаажуулалтын дараах хүндрэл бүртгэгдээгүй байна.

3.7 ЭМГазар нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Энэтхэг Улсад 2012 онд үйлдвэрлэгдсэн хугацаа нь дууссан улаанбурхан, гахайн хавдар, улаанууд вакциныг акталж хогийн цэгт шатааж, булж устгасан байна. Үүнийг устгахдаа Эрүүл мэндийн сайдын 2011 оны 11 дүгээр сарын 359 тоот тушаалаар батлагдсан "Вакцин, биобэлдмэлийн хаягдлыг устгах журам"-ын дагуу устгаж, журмаар батлагдсан вакцин, биобэлдмэлийн тээвэрлэн, устгасан тухай акт үйлдэж, комиссын дарга, гишүүдийн гарын үсгийг зуруулсан байна.

3.8 ЗӨСТөвөөс 2014 оны 07 дугаар сарын 15-наас 08 дугаар сарын 15-ны хооронд “Дархлаажуулалтын аян”-ны хүрээнд орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тархвар судлалын заалтаар хийгдэх тарваган тахлын дархлаажуулалтын урьдчилан сэргийлэх ач холбогдлыг тайлбарлан таниулахын зэрэгцээ бүх сум, өрхүүдэд дархлаажуулалттай холбоотой зөвлөмжийг албан тоотын хамт хүргүүлсэн байна. Мөн дархлаажуулалтын ач холбогдлыг харуулсан 210 ш сурталчилгааны зурагт хуудас, материал тараасан байна.

3.9 ЗӨСҮТөвөөс 2014 онд аймгийн ЗӨСТөвд захиалгаар ирүүлсэн тарваган тахлын 3000 хүн тунг өөртөө вакциныг хадгалах хүйтэн хэлхээний төхөөрөмж байхгүй тул аймгийн ЭМГазрын хүйтэн хэлхээний төхөөрөмжид хадгалж байгаад 2014 оны 07 дугаар сард зохион байгуулагдсан “Дархлаажуулалтын аян”-ны хүрээнд тус аймгийн 12 сум 1 тосгон болон аймгийн 4 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тархвар судлалын заалтаар голомтот нутгийн хүн амын эрсдэл бүхий бүлгийг хамруулахаар хуваарилсан байна. Вакциныг энэхүү аяны хүрээнд 2400 хүнд тарьж, 600 хүн тун асгалтанд хорогдсон байна. Энэ нь дархлаажуулалтын арга хэмжээнд зарцуулахаар татан авсан тарваган тахлын вакцины 20 хувийг эзэлж байна.

3.10 ЭМГазар нь 2013 оны 04 дүгээр сард 2014 оны дархлаажуулалтад шаардагдах вакцины захиалгыг ХӨСҮТөвд хүргүүлж, 2014 онд нийтдээ 12 төрлийн 68652 хүн/тун буюу 158.9 сая төгрөгийн товлोलт вакциныг татан авч, ЭМГазрын хүйтэн хэлхээний төхөөрөмжид хадгалж, дархлаажуулалтын арга хэмжээнд зориулсан байна.

Энэхүү 12 төрлийн 68652 хүн/тун вакцинаас нийтдээ 40718 хүн/тун вакциныг тарьж, 27400 хүн/ тун вакциныг найруулаад устгалд оруулсан байна. Өөрөөр хэлбэл 2014 онд устгалд оруулсан нийтдээ 27674 хүн/тун вакцинаас 27400 хүн/тун вакциныг найруулаад устгалд оруулж, үлдсэн 274 хүн/тун вакциныг хэрэглэх хугацаа нь дууссан тул холбогдох журмын дагуу акталж устгасан байна.

2014 онд дархлаажуулалтад зарцуулж, найруулаад устгалд оруулсан вакцины хорогдлыг вакцин тус бүрээр ХӨСҮТөвөөс тогтоож өгсөн жишиг түвшинтэй харьцуулж үзэхэд хорогдлын хувь, хэмжээ байвал зохих хэмжээнээсээ хэтрээгүй байна. Тухайлбал: Сүрьеэгийн вакцины тогтоосон жишиг хорогдлын хэмжээ нь 75% байсан бол 2014 оны хорогдлын хувь нь 4-р сард 73.4%, 5-р сард 72.4 %, 7-р сард 60%, 11-р сард 73.5% г. мэтээр буурсан үзүүлэлттэй байна.

Харин улаан бурхан, гахайн хавдар, улаануудын хавсарсан вакцины хорогдол 18.0 хувь, саагийн вакцины хорогдол 19.2 хувь, В гепатит вакцины хорогдол 31.9 хувь, сахуу татрангийн вакцины хорогдол 23.8 хувьтай байгаа нь ХӨСҮТөвөөс тогтоосон жишиг хорогдлын хувь, хэмжээнээс хэтрээгүй байгааг харуулж байна.

ЭМГазраас аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 7 хоногийн лхагва, баасан гаригуудад харьяа багуудын хүүхдүүдийг нэг дор цуглуулж вакцинжуулах арга хэмжээг авснаар хорогдлын хувь, хэмжээ тогтоосон түвшингээс хэтрээгүй байна. Ингэснээр 2014 оны эцэст 5781 хүн/тун буюу нийтдээ 22.1 сая төгрөгийн вакцины үлдэгдэлтэй гарчээ.

2014 онд товлोलт вакцинд нийтдээ Нэгдсэн эмнэлэг, 12 сум, 1 тосгон, 4 өрхийн эрүүл мэндийн төвийн хамрагдвал зохих 40718 хүн хамрагдсан байна.

Харин тус аймагт боомын өвчлөл 1982 оноос хойш бүртгэгдээгүй, 2002 оноос хойш тус аймгийн нутагт хөрс, бууц, малын цэг зэмнээс ямар нэгэн боомын үүсгэгч илрээгүй, боомын өвчлөлийн эрсдэлийн бүлгээр тус аймаг нь бага эрсдэлтэй бүлэгт ордог, хачигт энцефалитын өвчлөл огт бүртгэгдээгүй тул боомын болон иммуноглобулин вакцин захиалах шаардлага байхгүй байсан байна.

4. Дархлаажуулалтын сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй байгаа эсэх.

Сангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулж, хэрэгжүүлж ирсэн байна.

4.1 ХӨСҮТөвийн дархлаажуулалтын албаны дарга, хариуцсан мэргэжилтнүүд 2014 оны 04 дүгээр сард тус аймагт ирж дархлаажуулалтын үйл ажиллагаа, халууралт, тууралтын хам шинжийн урвал, цочмог сул саажилтын тандалтанд хяналтын үнэлгээ хийж, тус дэмжлэг хяналтаар аймгийн төвийн 4 өрхийн ЭМТөв, Сагсай, Цэнгэл сумдын дархлаажуулалтын хамралтанд чанарын үнэлгээ, Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн 2013 оны 900 хүүхдийн өвчний түүхэнд эргэмж судалгаа хийсэн байна.

4.2 ЭМГазраас Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн ЭМТөвүүдээс ирүүлж буй долоо хоног тутмын дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, цочмог сул саажилт, тууралтад халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй гэсэн “0” мэдээний эх үүсвэрийн бодитой эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

4.3 Нэгдсэн эмнэлэгт мэдрэлийн оношоор эмчлүүлэхээр хэвтсэн хүүхдүүдийн өвчний түүхэнд сар бүр цочмог сул саажилтын эргэмж судалгаа хийж, Өлгий сумын 0-5 насны 20 хүүхдээс вирус судлалын шинжилгээний сорьц цуглуулж, журмын дагуу хадгалан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн полиомиелитийн үндэсний лабораторид хүргүүлсэн байна.

4.4 ЭМГазраас 2014 онд харъяа 18 анхан шатны байгууллагад хүйтэн хэлхээний бүрэн бүтэн ажиллаж байгаа эсэх, хүйтэн хэлхээний хэмийн талаар өдөр тутмын тэмдэглэл хөтлөгдөж байгаа эсэх, дархлаажуулалтанд хамрагдах ёстой хүүхдүүд дархлаажуулалтанд бүрэн хамрагдсан эсэх, эрүүл мэндийн байгууллагын ажилчдыг сайн дурын дархлаажуулалтанд хамруулсан эсэхэд 2 удаа хяналт шалгалт, үнэлгээний ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлуудыг цаг тухайд нь засаж залруулсан байна. Мөн Нэгдсэн эмнэлэг, ЗӨСТөвийн дархлаажуулалтын үйл ажиллагаанд 1 удаа хяналт, үнэлгээ хийж, анхан шатны байгууллагуудын вакцин, биобэлдмэлийн захиалга бүрт хяналт тавьж ирсэн байна.

Үүнээс дүгнэлт хийж үзэхэд ЭМГазрын зүгээс дархлаажуулалтын сангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулж, хэрэгжүүлж ирсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

1. Дархлаажуулалтын сангийн үйл ажиллагааны талаар.

1. Дархлаажуулалтын сангийн тухай хууль, эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.
2. 2014 оны вакцинжуулалтанд шаардагдах вакциныг хуульд заасны дагуу зөв төлөвлөж, 68652 хүн/тун вакциныг татан авч, сангийн хөрөнгийг бүрдүүлжээ.
3. 2014 онд хүлээн авсан дархлаажуулалтын сангийн хөрөнгийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу зарцуулж, 40718 хүнийг вакцинжуулан зохих үр дүнд хүрсэн байна.
4. Эрүүл мэндийн газраас 2014 оны вакцинжуулалтын талаар тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулж, зохих үр дүнд хүрсэн байна.
5. Аймгийн төвийн эрүүл мэндийн бүх төвүүдэд хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжүүдийг холбогдох журмын заалтын дагуу хэвийн ажиллуулж, вакцин хадгалах хөргөгч, хөлдөөгчийн хэмийг журамд зааснаар хэвийн байлгаж, тусгай дэвтэрт байнгын хөтөлж ирсэн байна.
6. 2014 онд дархлаажуулалтад зарцуулж, найруулаад устгалд оруулсан вакцины хорогдол ХӨСҮТөөс тогтоож өгсөн жишиг түвшингийн хорогдлын хувь, хэмжээнээс хэтрээгүй байна.
7. 2013 оноос хойш ажилд шинээр орсон зарим ажилтан, ажилчид, бусад байгууллагын ажилчдыг 2014 онд сайн дурын вакцинд хамруулах арга хэмжээ авагдаагүй байна.
8. Сангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулж, хэрэгжүүлж ирсэн байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурьдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга С.Айгүл-д:

1. 2013 оноос хойш ажилд шинээр орсон зарим ажилтан, ажилчид болон журамд заасны дагуу бусад байгууллагын ажилчдыг сайн дурын вакцинд хамруулах арга хэмжээг зохион байгуулах.

Холбогдох байгууллагын санал

Аймгийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн санал:

БАЯН – ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
83127 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: 704225-11
hsic_bu@yahoo.com
www.health.bo.gov.mn

2015.09.23 № 596

танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас 2015 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны хүртэл хугацаанд "Дархлаажуулалтын сан"-гийн 2014 оны үйл ажиллагаанд хийгдсэн нийцлийн аудит нь холбогдох хууль, журмын дагуу үнэн, зөв хийгдсэн тул аудитын тайланд манай байгууллагын зүгээс ямар нэгэн оруулах санал байхгүй болно.

ДАРГА  С.АЙГҮЛ

БЮЕ0019

D:\A 5.docx

Холбогдох байгууллагын санал

Зоонозын өвчин судлалын төвөөс ирүүлсэн санал:



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ
2003818, Баян-Өлгий, Өлгий сум 4-р баг Их булан
Утас (7042-2569, E-mail: gotsbu@yahoo.com)

2015.09.23 № 76

танай _____ -ны _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дархлаажуулалтын сангийн 2014 оны үйл ажиллагаанд хийгдсэн нийцлийн аудит нь холбогдох хууль, журмын дагуу үнэн, зөв хийгдсэн тул аудитын тайланд манай байгууллагын зүгээс ямар нэгэн санал байхгүй болно.



ДАРГА

С.Алтынай

С.АЛТЫНАЙ

Бүлэг 2

Авто замын санд 2014 онд 256.6 сая төгрөгийн хөрөнгийг төвлөрүүлж, хөрөнгийг зориулалтаар нь зарцуулжээ.

Авто замын сангийн үйл ажиллагааны талаар:

1. Авто замын сангийн хууль, эрх зүйн зохицуулалт оновчтой эсэх.

Авто замын сангийн тухай хууль, эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.

1.1 Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн эсэх.

1.1.1 Монгол Улсын Их хурлаас Авто замын тухай хуулийг 1998 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр баталсан ба энэхүү хуулиар Монгол Улсын авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах, хамгаалах, ашиглах, санхүүжүүлэх, хянах болон төр, зам ашиглагч байгууллага, иргэний хооронд энэ талаар үүсэх харилцааг зохицуулсан байна.

1.1.2 Хуулийг хэрэгжүүлэхтэй уялдан Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”- ыг баталсан байна. Авто замын сан нь Авто замын тухай хууль, Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Авто замын тухай хуулийн 18.1-д заасны дагуу “Улсын авто зам нь замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, орон нутгийн авто замын сан нь аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд байна”, мөн энэхүү хуулийн 18.3-т “авто замын сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, Авто замын тухай хууль, тогтоомжийн биелэлтэд мэргэжлийн хяналт тавихад шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн авто замын сангаас санхүүжүүлнэ” гэж заажээ.

1.2 Авто замын сангийн тухай хууль, дүрэм, журмууд нь сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх.

1.2.1 Авто замын сангийн тухай 1998 онд батлагдсан хууль, Монгол Улсын засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам” нь сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулсан байна.

1.3 Авто замын сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмууд нь бусад хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэх.

1.3.1 Авто замын сангийн үйл ажиллагааг зохицуулж буй Авто замын тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам” нь Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, бусад хууль, тогтоомжтой нийцэж байна.

2. Авто замын сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлсэн эсэх.

Авто замын санд 2014 онд хуульд заасны дагуу 256.6 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлсэн байна.

2.1 Авто замын хөрөнгийг хуульд заасны дагуу үндэслэлтэй төлөвлөсөн эсэх.

2.1.1 Авто замын тухай хуулийн 18.1-д заасны дагуу “Улсын авто зам нь замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, орон нутгийн авто замын сан нь аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд байна”, мөн хуулийн 18.2-т “Улсын авто замын сангийн хөрөнгө нь улсын төсвийн, орон нутгийн авто замын сангийн хөрөнгө нь аймаг, нийслэлийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болох бөгөөд түүнийг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, гүйцэтгэлийн тайлан мэдээ гаргах ажиллагааг тухайн төсвийн нэгэн адил журмаар хэрэгжүүлнэ”, 18.3-т “авто замын сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, Авто замын тухай хууль, тогтоомжийн биелэлтэд мэргэжлийн хяналт тавихад шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн авто замын сангаас санхүүжүүлнэ”, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг орон нутгийн замын санд төвлөрүүлэн зарцуулж байна” гэсэн заалтуудыг мөрдөж ажилласан байна.

Өөрөөр хэлбэл хуулийн дээрхи заалтуудын дагуу Орон нутгийн замын санд төвлөрүүлэх хөрөнгийг Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 8-д “орон нутгийн замын сангийн хөрөнгийн хэмжээ, хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймаг, нийслэлийн ИТХурал батална” гэж заасны дагуу тус аймгийн орон нутгийн замын санд 2014 онд төвлөрүүлэх хөрөнгийг 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар 243.5 сая төгрөгөөр төлөвлөн баталсан байна.

2.2 Авто замын хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төрөл тус бүрээр бүрдүүлсэн эсэх.

2.2.1 Тус аймгийн орон нутгийн замын сангийн хөрөнгө нь 2014 оны эхэнд дансанд 46.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тухайн онд уг санд Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу АТБӨЯХАТатварын орлогоос 243.5 сая төгрөгийн, бусад орлогоос 13.1 сая төгрөгийн хөрөнгийг тус тус төвлөрүүлж, 2014 онд төсөл, арга хэмжээнүүдэд болон бусад арга хэмжээнүүдэд нийтдээ 268.4 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, оны эцэст сангийн дансанд 35.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт№01

№	Төвлөрүүлсэн хөрөнгө	Оны эхний үлдэгдэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Оны эцсийн үлдэгдэл
1	Орон нутгийн орлогоос санхүүжүүлсэн	46.8	243.5	268.4	24.9	35.0
2	Бусад орлого	=	13.1	=		
	Дүн	46.8	256.6	268.4		35.0

2.2.2 Орон нутгийн авто замын 2014 оны хөрөнгөөс зарцуулсан нийтдээ 268.4 сая төгрөгийн хөрөнгөөс 241.0 сая төгрөгийн хөрөнгийг 2014 онд хэрэгжсэн 14 төрлийн төсөл, арга хэмжээнд, 0.3 сая төгрөгийн хөрөнгийг Цэнгэл сумын Шар говийн хатуугийн замын засварын өнгөрсөн оны дутууд, 2.8 сая төгрөгийн хөрөнгийг МХГазрын хяналтын зардалд тус тус зарцуулж, 24.3 сая төгрөгийн хөрөнгийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, Сангийн сайд, Зам, тээврийн сайдын 2013 оны 101 дүгээр сарын 23-ны өдрийн 20/19 тоот тушаалын дагуу жолоочийн даатгалын санд төвлөрүүлсэн байна.

3. Авто замын хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулж, үр дүн гарсан эсэх.

Авто замын сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулжээ.

3.1 Авто замын хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байгаа эсэх.

3.1.1 2014 онд Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт буюу төсөл, арга хэмжээг тус аймгийн төсвийн чадавхид суурилан 2014 оны төсвийн төлөвлөгөөнд тусгаж, аймгийн ИТХурлын хуралдааны болон Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан байна.

3.1.2 2014 онд замын сангийн хөрөнгөөр нийтдээ 246.9 сая төгрөгийн /Анхны төсөвт өртгөөр/ 14 төсөл, арга хэмжээг орон нутагт зохион байгуулж, хэрэгжүүлэхээр төлөвлөж баталжээ.

3.1.3 Эдгээр хөрөнгө оруулалт буюу төсөл, арга хэмжээнүүдийг баталсаны дараа зураг төсөв, ажлын төсөвт өртгийг хийсэн байна.

3.1.4 Энэхүү орон нутагт хэрэгжүүлсэн 14 төсөл, арга хэмжээний хөрөнгийн бүтцийг авч үзэхэд 0.6 сая төгрөгийн хөрөнгийг тоног төхөөрөмж худалдан авахад 102.3 сая төгрөгийн хөрөнгийг сумдын зам засах, засварлах, хар замын нөхөөсийн засвар хийх, 130.0 сая төгрөгийн хөрөнгийг шинээр гүүр барихад 14.0 сая төгрөгийн хөрөнгийг хуучин гүүрийг засварлахад зарцуулсан байна.

3.2 Төсөл, хөтөлбөрийг ТБОНӨХБАУХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулсан эсэх.

3.2.1 Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2014 онд хэрэгжихээр төлөвлөгдсөн 14 төсөл, арга хэмжээг аймгийн Худалдан авах ажиллагааны алба, орон нутгийн харьяа байгууллага болон төсвийн шууд захирагчид худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.

Энэхүү төсөл, арга хэмжээнээс худалдан авах ажиллагааны 4-ийг нь Худалдан авах ажиллагааны албанаас, 1-ийг тухайн сумаас зохион байгуулж, Төрийн болон

орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33, 34 дүгээр зүйл, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын заалтуудыг үндэслэн ажлын хэсэг байгуулж, тендер зарлаж, 5-ыг нь харьцуулалтын аргаар шалгаруулж, шалгарсан төсөвт багтаан гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулах саналаа өгч, холбогдох захиалагч байгууллагууд нь гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн бол 9-ийг нь шууд худалдан авах гэрээ байгуулах хэлбэрээр хэрэгжүүлсэн байна.

3.2.2 Худалдан авах ажиллагааны албанаас Үнэлгээний хороо байгуулж, тендерийн урилга нийтлэх, гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд нэг тендэрт 8-19 хоног зарцуулжээ.

3.3 Авто замын хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь гэрээний шаардлагыг хангасан эсэх.

3.3.1 Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2014 онд хэрэгжүүлсэн 14 төсөл, арга хэмжээ нь гэрээний шаардлагыг бүрэн хангаж, хугацаанд нь ашиглалтанд өгч, гүйцэтгэгч, ашиглагч байгууллагын хооронд ямар нэгэн гомдол, маргаан гараагүй байна.

3.4 Авто замын хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь зорилтот үр дүнд хүрсэн эсэх.

3.4.1 Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлагдсан 246.9 сая төгрөгийн /гэрээнд заасан дүнгээр/ 14 төсөл, арга хэмжээг ондоо багтаан бүрэн хэрэгжүүлж, ашиглалтанд авах комисст хугацаанд нь хүлээлгэн өгч, тухайн жилд ашиглагч байгууллагын данс бүртгэлд орлого авахуулж, жилийн эцсийн тайлан тэнцэлд тусгуулсан байна.

Харин нэг төсөл, арга хэмжээнээр бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагын 2014 оны данс, бүртгэлд орлого авч, тухайн жилийн тайлан, тэнцэлд тусгаагүй байсан нь 2015 оны 04 дүгээр сард хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар тогтоогдож, албан шаардлага өгөгдөж, илэрсэн зөрчил, дутагдлуудыг хугацаанд нь арилгуулсан байна. Тухайлбал:

1. Цэнгэл сумын Загаст нуур багийн Цагаан голд баригдаж ашиглалтанд өгсөн 80.0 сая төгрөгийн мордон гүүрийг 2014 онд холбогдох ашиглагч байгууллагуудын дансанд орлого авч, жилийн эцсийн тайлан тэнцэлд тусгаагүй байсан тул 2015 оны эхний хагас жилд багтаан ашиглагч байгууллагуудад үүрэг өгч дансанд орлого авч, хагас жилийн тайлан тэнцэлд тусгуулсан байна.



Цэнгэл сумын Загаст нуур багийн Цагаан голын модон гүүр

4. Дотоод хяналт үр нөлөөтэй байгаа эсэх.

Авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулж ажиллаж ирсэн байна.

4.1 Дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн эсэх.

4.1.1 Авто замын тухай хуулийн 18.3-т “Авто замын сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, автозамын тухай хууль тогтоомжийн биелэлтэд мэргэжлийн хяналт тавихад шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн авто замын сангаас санхүүжүүлнэ”, Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 10-т “Улсын болон орон нутгийн замын сангийн хөрөнгөөр барьж байгуулах, их засвар, өргөтгөл, засвар арчлалт хийх, зам, замын байгууламжийг барих, гэрээ байгуулан түүний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг Авто замын газар, аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцана”, 19-д “орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд тавих мэргэжлийн техникийн хяналтыг аймаг, нийслэлийн Засаг даргын зохих албад хариуцан хэрэгжүүлнэ” гэж тус тус заасны дагуу аймгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аймгийн МХГазар, Тээвэр, авто замын газраас зохих хяналт тавьж ажилласан байна.

4.1.2 Замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн техникийн нөхцөлийг хангуулах, гүйцэтгэж байгаа ажлын явц, гүйцэтгэлд нь захиалагч болон ашиглагчийн зүгээс хяналт тавих, ажлын бодит гүйцэтгэлийг үнэн зөв тооцох талаар гэрээнд тодорхой тусгажээ. Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд гүйцэтгэгчээс гаргасан ажлын гүйцэтгэлийг тухай бүр хянаж баталсаны дагуу санхүүжилтийг олгож ирсэн байна.

4.1.3 Ажлын гэрээнд захиалагч болон ашиглагч байгууллагууд гэрээ хийж байгаа ба ашиглалтанд хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд ашиглагч байгууллагын төлөөлөл зайлшгүй орж актад гарын үсэг зурж байгаа нь ашиглагч байгууллага төсөл, арга хэмжээний ажлын явц, үр дүнд хяналт тавих эрхээр хангагдаж, тухайн ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ирсэн байна.

Ингэснээр замын сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа аливаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавигдах дотоодын хяналтын тогтолцоо үндсэндээ бүрдсэн байна.

4.2 Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдэж байгаа эсэх.

4.2.1 Орон нутгийн замын хөрөнгөөр 2014 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, хэрэгжилтийн байдалд аймгийн МХГазрын авто замын хяналтын улсын байцаагчийн зүгээс 13 удаа буюу 21 хүн/өдөр хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж, 1 акт тогтоож, 11 дүгнэлт гаргаж, 1 зөвлөмж өгч хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлуудыг хугацаанд нь засаж залруулах, арилгуулах талаар тодорхой арга хэмжээ авч, биелэлтийг бүрэн хангуулсан байна.

Ингэснээр авто замын сангаас МХГазрын авто замын хяналтын улсын байцаагчийн хийсэн хяналт шалгалтын ажлын үр дүн буюу гүйцэтгэлээр хяналт, шалгалтын үйл ажиллагааны зардалд оны эцэст 2.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

4.2.2 Аймгийн Тээвэр, авто замын газар нь аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний дагуу орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаа, замын арчлалт, гүүрийн угсралт, замын засварын ажилд 2014 онд 10 удаа хяналт, шалгалт хийж, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлуудыг арилгах, засаж залруулах талаар дүгнэлт, зөвлөмж өгч, биелэлтэнд хяналт тавьж ажилласан байна. Энэхүү сангийн хөрөнгөөс хяналтын зардалд 3.2 сая төгрөгийн хөрөнгө олгожээ.

4.2.3 Тус Аудитын газраас 2015 оны 4 дүгээр сард орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитаар тус сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудит хийхэд тухайн онд бүрэн хэрэгжиж, ашиглалтанд хүлээж авах комисст хүлээлгэж өгсөн боловч ашиглагч байгууллагын данс бүртгэлд орлого авч тухайн жилийн тайлан тэнцэлд тусгаагүй нийтдээ 80.0 сая төгрөгийн хөрөнгийг 2015 оны эхний хагас жилд данс бүртгэлд орлого авч, тайлан тэнцэлд тусгуулахаар албан шаардлага өгч, биелэлтээ бүрэн хангуулсан байна.

4.3 Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг ил тод нээлттэйгээр олон нийтэд мэдээлж байгаа эсэх.

4.3.1 Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь орон нутгийн замын сангийн хөрөнгийн 2014, 2015 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагааны талаар Төрийн сангийн дотоод сүлжээ, орон нутгийн дундын сүлжээ, Аймгийн ЗДТГазрын самбарт байршуулж, иргэдэд ил тодоор сурталчилж ажилласан байна.

4.3.2 Харин Худалдан авах ажиллагааны алба нь 2014 оны орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, тендерийн үйл ажиллагаа, 2015 оны төлөвлөгөө, 2014 оны 4 төрлийн төсөл, арга хэмжээний тендерийн урилга, тендерийн бичиг баримт, тендерийн зураг, төсөв нэмэлт материалуудыг Худалдан авах ажиллагааны газрын www.tender.bo.gov.mn, www.bayan-olgii.gov.mn, www.meps.gov.mn, e-procurement.mn веб сайтуудад байршуулсан байна.

Энэхүү аудитаар ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй болно.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

2. Автозамын сангийн үйл ажиллагааны талаар.

1. Авто замын сангийн тухай хууль, эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.
2. Авто замын санд 2014 онд хуульд заасны дагуу 256.6 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлсэн байна.
3. Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүдийг ондоо багтаан бүрэн хэрэгжүүлсэн байна.
4. Авто замын сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулжээ.
5. Авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулж ажилласан байна.
6. Авто замын сангийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийн талаархи мэдээлийг Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу байршуулж, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

Холбогдох байгууллагын санал

Аймгийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн санал:


**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-37-82

2015.09.23 № 5-03/2266
танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн авто замын сангийн 2014 оны үйл ажиллагаанд хийгдсэн нийцлийн аудит нь холбогдох хууль, журмын дагуу үнэн зөв хийгдсэн тул аудитын тайланд манай байгууллагын зүгээс ямар нэгэн оруулах санал байхгүй болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Б.ШОЛПАН

Бүлэг 3

Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийг холбогдох
хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, зарцуулалтанд хяналт
тавьж ажилласан байна.

Шинжлэх ухаан технологийн сангийн үйл ажиллагааны талаар:

1. Шинжлэх ухаан технологийн сангийн хууль, эрх зүйн зохицуулалт оновчтой эсэх.

*Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль эрх
зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.*

1.1 Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн эсэх.

1.1.1 Шинжлэх Ухаан технологийн сан нь 1993 оны 12-р сарын 24-нд Монгол Улсын Засгийн газрын 192-р тогтоолоор шинжлэх ухааны салбарын байгууллагуудын санхүүжилтийг үр дүнтэй санхүүжүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор байгуулагджээ.

1.1.2 Шинжлэх ухааны тухай хууль 2006 онд батлагдаж, хуулийг хэрэгжүүлэхтэй уялдан Монгол улсын Засгийн газрын 2010 оны 36 дугаар тогтоолоор “Шинжлэх ухаан, технологийн төсөл, сэдэвт ажил хэрэгжүүлэх журам”-ыг баталж, энэхүү журмын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Сэдэвт ажил буюу төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, түүний үр дүнг баталгаажуулах, үнэлэх, хүлээлгэн өгөх, үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд шилжүүлэх, ашиглах, урамшуулах ажлыг холбогдох хууль тогтоомж болон шинжлэх ухаан, технологийн төсөл, сэдэвт ажил хэрэгжүүлэх журам, түүнд нийцүүлж гаргасан бусад дүрэм, журам, заавар, аргачиллын хүрээнд хийж гүйцэтгэнэ гэж заажээ. Ингэснээр сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

1.2 Шинжлэх ухаан технологийн сангийн тухай хууль, дүрэм, журмууд нь сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх.

1.2.1 Шинжлэх ухаан технологийн сангийн тухай хууль, Монгол Улсын засгийн газрын 1993 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан “Шинжлэх ухаан технологийн сангийн тухай дүрэм”-д заасны дагуу сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулсан байна.

1.3 Шинжлэх ухаан технологийн сангийн тухай хууль, дүрэм, журмууд нь бусад хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэх.

1.3.1 Шинжлэх ухаан технологийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй Шинжлэх ухаан технологийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн тогтоол, бусад хууль, тогтоомжтой нийцэж байна.

2.Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлсэн эсэх.

Тус аймгийн Шинжлэх ухаан технологийн сан нь 2014 онд 139.0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ.

2.1 Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу үндэслэлтэй төлөвлөсөн эсэх.

2.1.1 Шинжлэх ухаан технологийн сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-ийн 15.1.1-т “Засгийн газрын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр”, мөн хуулийн 15.1.2-т “Нутгийн захиргааны байгууллагын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр”, 18.1.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг захиалагчийн хөрөнгөөр”, санхүүжүүлнэ гэсэн заалтуудыг мөрдөж ажилласан байна.

Тус аймгийн НЭЗСТөвийн Шинжлэх ухаан технологийн санд 2014 онд 139.0 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөн, улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

2.2 Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төрөл тус бүрээр бүрдүүлсэн эсэх.

2.2.1 Тус аймгийн НЭЗСТөвийн Шинжлэх ухаан технологийн санд 2014 онд 139.0 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөн төвлөрүүлж, өөрийн орлогоос 0.4 сая төгрөгийн, нийтдээ 139.4 сая төгрөгийн санхүүжилт авч, 2 төрлийн төсөл, судалгааны ажилд хууль, журмын дагуу зарцуулсан байна.

3. Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулж, үр дүн гарсан эсэх.

Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, судалгааны ажлыг журмын дагуу зохион байгуулжээ.

3.1 Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байгаа эсэх.

3.1.1 2014 онд Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгөөр 2 төрлийн төсөл, судалгааны ажлыг 139.0 сая төгрөгөөр орон нутагт зохион байгуулж, хэрэгжүүлэхээр төлөвлөж, зарцуулсан нь тухайн төсөл, арга хэмжээний зорилго, зорилттой нийцэж байна.

3.2 Төсөл, хөтөлбөрийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулсан эсэх.

3.2.1 Тус аймгийн НЭЗСТөвд 2014 онд хэрэгжүүлсэн 139.0 сая төгрөгийн 2 төрлийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг захиалагч болох Боловсрол Шинжлэх Ухааны Яамнаас тендерийг түүгээрээ зарлаж зохион байгуулсан байна.


3.3 Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь гэрээний шаардлагыг хангасан эсэх.

3.3.1 Тус сангийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлсэн 2 төрлийн төсөл, арга хэмжээ судалгаа нь гэрээний шаардлагыг бүрэн хангаж, дууссан сэдэвт ажлын эрдэм шинжилгээний тайланг зохих журмын дагуу цаг хугацаанд нь холбогдох байгууллагад тайлагнаж хүлээлгэн өгсөн байна.


3.4 Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрсэн эсэх.

3.4.1 НЭЗСТ нь Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгөөр 2014 онд 139.0 сая төгрөгийн 2 төсөл, хөтөлбөрийг тус байгууллагын үндсэн зорилго болох шинэ мэдлэг мэдээллийн баялаг бүтээж түүнийгээ гадаад дотоодын эрдэмтэдэд толилуулж, дэлхийн шинжлэх ухааны эргэлтэд оруулж ард иргэдэд хүргэн түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлж, шинэ мэдлэг мэдээлэл бий болгох зорилтоо биелүүлсэн байна.

Үүнд: 1. “Казах ардын ёс заншлууд” /Казах халкынын салт-дастүрлери/ казах хэлээр 98,6 х.х бүтээл. Уг бүтээл нь доктор К.Бихумар агсаны амьд сэрүүндээ бичиж нийтлүүлсэн бүтээлүүд болон гар бичмэлийг янзлан редакторлож нийтийн хүртээл болгосон томоохон бүтээл юм. Энэ нь “Баян-Өлгий аймгийн үндэстэн ястаны биет ба биет бус соёлын өвийн судалгаа” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хэрэгжүүлж нийтийн хүртээл болгосон байна.



“Казах халкынын салт-дастүрлери”



“Алтайн урианхайн угсаатны зүй”

2. “Алтайн урианхайн угсаатны зүй” /25,6 х.х, академик боть/ хамтын бүтээлийг хэвлүүлж нийтийн хүртээл болгожээ. Энэ нь мөн “Баян-Өлгий аймгийн үндэстэн ястаны биет ба биет бус соёлын өвийн судалгаа” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хэрэгжүүлж шинэ мэдлэг мэдээллийг нийгэмд түгээн дэлгэрүүлсэн ажил юм.

3. “Цагаан соён Чолоогийн Дамчаа” намтар судлалын бүтээл хэвлүүлж “Намтар судлалыг хөгжүүлэн дэлгэрүүлэх” гэсэн байгууллагын манлайлалын зорилтыг хэрэгжүүлсэн байна.

4. “Монгол Алтайн нурууны эмийн ургамал” хамтын бүтээл хэвлүүлж “Монгол Алтайн нурууны эко системийн судалгаа” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангаж ажиллажээ.

5. “Шинэ мэдээлэл мэдлэгийн эх орондоо болон гадаад орнуудад сурталчлах” байгууллагын үндсэн зорилтын хүрээнд гадаадад 7, дотоодод 6 өгүүлэл, гадаадад 4, дотоодод 8 илтгэл тавигдаж нийтийн хүртээл болгож, дэвшүүлсэн зорилтоо бүрэн хэрэгжүүлэн үр дүнд хүрсэн байна.

4. Дотоод хяналт үр нөлөөтэй байгаа эсэх.

Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулж ажиллаж ирсэн байна.

4.1 Дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн эсэх.

4.1.1 ШУТСангийн үйл ажиллагаанд байнга дотоод хяналт явуулж “Сар бүрийн санхүүгийн мэдээ”-г сар бүрийн 28-наас өмнө гаргаж явуулсан ба хагас бүтэн жилийн санхүүгийн тайланг ШУТС-гаар хянуулж, дотоод хяналтын системийг нэвтрүүлж ажиллаж ирсэн байна.

Ингэснээр ШУТСангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа аливаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавигдах дотоодын хяналтын тогтолцоо үндсэндээ бүрдсэн байна.

4.2 Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдэж байгаа эсэх.

4.2.2 Эрдэм шинжилгээний байгууллагын сар, улирал бүр хийсэн ажлаа байгууллагын хурлаар авч хэлэлцэж, улмаар ШУА-д тайлан бичиж хүргүүлэн хянуулах, дутуу дулимаг хийгдсэн ажлыг дахин засварлан хийх тогтолцоогоор дээд шатны байгууллагадаа ажлаа байнга тайлагнаж, хянуулж иржээ.

4.3 Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг ил тод нээлттэйгээр олон нийтэд мэдээлж байгаа эсэх.

4.3.1 ШУТСангийн хөрөнгийн 2014, 2015 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагааны талаар Төрийн сангийн дотоод сүлжээ, НЭЗСтөвийн самбарт байршуулж, иргэдэд ил тодоор сурталчилж ажилласан байна.

Энэхүү аудитаар ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй болно.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

3. ШУТСангийн үйл ажиллагааны талаар.

1. ШУТСангийн тухай хууль, эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.
2. Шинжлэх ухаан технологийн сангийн батлагдсан төсөвт хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, судалгааны ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулжээ.
3. Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулж ирсэн байна.
4. Шинжлэх ухаан технологийн сангийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийн талаархи мэдээлийг Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу байршуулж, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

Холбогдох байгууллагын санал

Шинжлэх ухааны академийн Баян-Өлгий аймаг дахь Нийгэм эдийн засгийн судалгааны төвөөс ирүүлсэн санал:


МОНГОЛ УЛС
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ НИЙГЭМ
ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг
Утас Факс (01-422)2-21-34, 2-35-84
E-mail: ac.nezst@yahoo.com

2015/09/22 № 1/125

танай _____-ны № _____-т

Баян-Өлгий аймгийн Аудитын газарт

Шинжлэх ухааны технологийн сангийн 2014 оны үйл ажиллагаанд хийгдсэн нийцлийн аудит нь холбогдох хууль, журмын дагуу үнэн зөв, хийгдсэн тул аудитын тайланд манай байгууллагын зүгээс ямар нэгэн оруулах санал байхгүй.

Захирал Г.Золбаяр



ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БЕКЕН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ С.САЛТАНАТ

ШИНЖЭЭЧ Х.ЕРКЕБУЛАН